

Mongolian A: literature – Standard level – Paper 1
Mongol A : littérature – Niveau moyen – Épreuve 1
Mongol A: literatura – Nivel medio – Prueba 1

Friday 8 May 2015 (afternoon)
Vendredi 8 mai 2015 (après-midi)
Viernes 8 de mayo de 2015 (tarde)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

Instructions to candidates

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a guided literary analysis on one passage only. In your answer you must address both of the guiding questions provided.
- The maximum mark for this examination paper is **[20 marks]**.

Instructions destinées aux candidats

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez une analyse littéraire dirigée d'un seul des passages. Les deux questions d'orientation fournies doivent être traitées dans votre réponse.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est de **[20 points]**.

Instrucciones para los alumnos

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un análisis literario guiado sobre un solo pasaje. Debe abordar las dos preguntas de orientación en su respuesta.
- La puntuación máxima para esta prueba de examen es **[20 puntos]**.

Доорх хоёр зохиолоос зөвхөн **нэгийг** нь сонгож, хөтөч хоёр асуултын дагуу уран зохиолын талаас задлан тайлбарлаж бич.

1.

Энэхүү шинэ бэр хэмээгч Санжид өвгөний бага охин. Түүний нэр Мядагмаа хэмээмүй. Санжид өвгөний урагшид өгсөн хоёр охин цөм өнгөтэй ховор төрсөн учир, хүрээ хотын олон хүн магтаж нэгэн дуу гарсан нь:

5 *Саруул дэлхийд сайхан эхнэр олон боловч,
Санжид өвгөний гэр дэх мэт сайхан өнгө цөөхөн,
Сайхан төрсөн охин түүнийг хэн хүн авбал,
Сайн төрд хааны авхайгаас дээр, хэмээжээ.*

10 Ерийн үгэнд, “Худалдаа хийж эс олбол, ганц нэгнээс зовмуй. Аяа, сайхан эм эс олбол нэгэн насанд зовмуй” гэдэг зүйлийг санаж, Сайжрахын бие Санжид өвгөний охиныг сайхан хэмээн сонсоод бяцхан дор бэлэг хүргэн хөвгүүндээ гуйн тогтжээ. Энэ өдөр буулган авч ирсэнд үнэхээр өнгө зүс хэтэрхий сайхан, түүний бие хоёр эгчээсээ нэн илүү ховор төрсөн тул, энэ хоёр хүн бус, нөхөр эмээс нэн арван хувь илүү өршөөл найртай учир шилэн цонхтой давхар байшингийн дээр хоёул төгс хослон сууна. Өглөө үдэш жаргалдан цэнгэлдэж, үнэхээр сууж босовч салахгүй, нойр зүүдэнд ч мөн нөхөрлөнө. Ийнхүү агсаар зовлонгийн өдрийг хүлчхүйд удаан, жаргалангийн цагийг өнгөрүүлэхүйд хурдан тул зун одож өвөл ирэн, удсангүй нэгэн жил өнгөрч, нэгэн өдөр Радна эцгээ байх үед Тарвагатайн газар хэдий чинээ авлага үлдээснийг санагалзаж, эдүгээ гурван жил илүү болтол очсонгүй хэмээн үдэш гэрийн эмтэйгээ зөвлөж нэгэн удаа очсугай хэмээхэд, гэргий нь, анханд харин очвол зохино гэсэн бөлгөө. Хожимд хэдий чинээ хол замыг сонсоод амраг халуун нөхөр эм юунаа салж төвдөх ажээ. Санамсаргүй хоёр нүднээс нулимс цувруулж, Радна ч мөн салж төвдөхгүй тул, хоёулан нэгэн зэрэг сэтгэл өвдөн алслан одохыг хорив. Ийм болсон нь нэгэн удаа бус. Хоёр янагуудад жил өнгөрөх нь цаг өнгөрөхөөс хурдан мэдэгдэлгүй байсаар, бас хоёр жил өнгөрөв. Тэр үед Радна одсугай хэмээн санаа тогтоод гэргийгээсээ гадуур сэм бэлтгэж, ачаа хөсгөө засаад, нэгэн дээд сайн өдрийг сонгож, түүнээс таван өдрийн урьд сая гэргийдээ сонсгож өгүүлрүүн: “Ерийн үгэнд сууж идвэл, уул ч барагдана, хэмээжээ. Бид нөхөр эм хоёулан мөн хөрөнгө байгуулж гэр бүтээвэл зохих болой. Энэ нэгэн зүйлийн идэж өмсөх замыг гээвэл болно уу. Эдүгээ энэ хавар цагийн өдөр хүйтэн халуун тэгш, алс замд гарч явахгүй бас ямар цагийг хүлээнэ” хэмээсэнд, гэргий нь хориглон зогсоож чадахгүйгээ мэдээд, аргагүй асууруун: “Нөхөр, энэ удаа одохуйдаа хэдийд эргэж ирмүй?” хэмээвээс, Радна өгүүлрүүн: “Миний энэ удаагийн гадагш гарах нь маш аргагүйд болой. Сайн муу алин боловч нэгэн жилд эргэж ирнэ” хэмээв. “Хожмын дахиж одохыг хичээх буй заа” хэмээсэнд, гэргий нь тэндээс үзэгдэх өмнөх нэгэн их уулын модыг зааж, өгүүлрүүн: “Хойтон жил энэ уулын модны мөчрийг хөхрөхүйд хүүгийн минь эргэж ирэх хэмжээ дуусмуй” хэмээн хэлж бармагц бороон орох мэт нулимсан асгаруулав. 35 Радна дээлийн ханцуйгаар нулимсыг арчихүйд санамсаргүй өөрийн нулимсан нь сувдан хэлхээ тасарсан мэт асгарав. Хоёр этгээдийн хагацахдаа гаслан, салахдаа зовнин эмгэнэх гашууныг нэгэн үгэнд барахуйяа бэрх. Тавдугаар өдөрт хүрсний хойно нөхөр эм хоёулан энэлэн шаналан, гашуудан тэврэлдэн нэгэн шөнө сул хэлэлцэж бяцхан ч унтсангүй, таван цагийн үед Радна даруй босож дээл хувцсаа өмсөөд өвөөгийн үлдээсэн алтан сувдын бөөртэй улаан шүрэн эрхийг гэргийдээ өгөөд биедээ гагц үнэ, мөнгө зоос, 40 авлагын данс бичиг, дээл хувцас, хөнжил дэвсгэрийг авч, бас хүнд хүргэх бэлгийн юмыг бага зэрэг аваад, угаас хоёр зарц байсан тул нэгэн залууг өөрөө дагуулан, үлдсэнийг гэртээ үлдээж, бас Дулам хэмээх нэгэн охиныг “гагц Мядагмаагийн дэргэд зарагдан наадтугай, хол ангижирч болохгүй” хэмээн захиж дуусгаад, бас гэргийн

- 45 зүг өгүүлрүүн: “Хүү минь, сэтгэл тавьж аж төрөгтүн. Энэ газрын хөнгөн нимгэн дүү нар цөөнгүй. Чиний төрсөн нь бас сайхан. Битгий үүднээ гарч илрэн, салхиныг өдөөж, галыг үлээ” хэмээвээс, гэргий нь өгүүлрүүн: “Аяа, хүү минь, сэтгэлээ сул тавьж хурдан очоод, хурдан ир” гэж хоёулаа арчиж салалцав.

Д Бодоо, Үзэмжит өгүүлэл*

* Энэ зохиолыг бичсэн он нь тодорхойгүй байдаг бөгөөд 1910–1920 оны хооронд бичигдсэн гэж үздэг.

- (а) Зохиолч Раднагийн дүрийг хэрхэн дүрсэлж гаргасан байна вэ?
- (б) Зохиолчийн ашигласан зүйрлэл, хэтрүүлэл зэрэг уран дүрслэлийн аргуудыг тайлбарлан бич.

2.

- Нарийн гайхамшигт салхин бадарч
Найртай амьсгал гэсэн дэлгэрч
Нарны гэрэл шадар ойртож
Хамаг бодис хөврөн дэлгэрч
- 5 Харьсан шувуу хариу эргэж
Хаврын улирал орж ирэхийн цагт
Хангарьд хамаг шувууны
Сүрийг дарагч адил
Сүр жавхлан бадарсан
- 10 Хавтай идэрхэг Ханхөхий минь
Бадмаараг эрдэнэ адил
Хүрэнтэж гэрэлтээд
Хөшиглөж дуниараад харагдана билээ.
Хөрст (алтан) дэлхийн цасан нь хайлж
- 15 Хөлдсөн бүгд нь гэсэн урсаад
Хөдөө талын өвс хөглөрч
Хөх бог нь дэлгэн гараад
Хөрөнгө үндэс нь амьжраад ирэхийн хэрд
Хүй хөвчинд нь багтаж төрсөн
- 20 Хүн амьтны сэтгэл баясаад
Хүй элэгнээрээ золголдон хүүрнэж
Хөгжилтэй наадмаар тоглолцож цэнгэлдээд
Хүссэн эрлээн ханан гүйцэтгэж
Бурхан шашныг дэгжүүлэн
- 25 Бурсан хуврагуудыг хүндэтгэж
Буян чуулганыг хурааж
Буян бусыг тэвчиж
Бузар хилэнцийг наминчлаад
Жисаа номоо уншуулж
- 30 Зэтгэр түйтгэрийг арилгаж байдаг билээ.
Эдгээр амарлингуйн хамаг үйлс бүгдийг бүтээгч энэ нь
Гагцхүү ачлалт Богд Ханхөхийн минь ачлал болмой.

С Лувсандондов, *Эрдэнэт богд Ханхөхийн магтаал* (1880)

- (а) Зохиогч Ханхөхий уулын талаар хэрхэн дүрсэлсэн байна вэ?
- (б) Зохиогч хөг хэмнэлийг хэрхэн тааруулсан тухай тайлбарлан бич.